

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ¹ 20 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 14.30 цагт эхэлж, 16.30 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 2 цаг 00 минут үргэлжлэв.

| 1 | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|---|---|
| 1 | Тагнуулын ерөнхий газарт ажилтан асан В.Нямханд, С.Энхтайван, Р.Азбаяр нарын ажлаас үндэслэлгүй халагдсан тухай гаргасан гомдлыг шалгасан Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай | Тагнуулын ерөнхий газрын Хоёрдугаар газрын нэгдүгээр хэлтсийн ахлах ажилтан хошууч Р.Азбаяр, Нийслэл дэх газрын орлогч дарга, дэд хурандаа В.Нямханд, тус газрын ахлах ажилтан, ахмад С.Энхтайван нарыг “Ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон Тагнуулын албан хаагчийн ёс зүйн дүрмийн холбогдох заалтуудыг зөрчиж, сахилгын ноцтой зөрчил гаргасан” гэх үндэслэлээр албанаас халсан Тагнуулын ерөнхий газрын даргын 2009 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 140 дүгээр тушаал, уг тушаалыг хууль ёсны гэж үзсэн Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2009 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов. |
| 2 | Улсын Их Хурлын Чуулган, байнгын хорооны хуралдаан зохион байгуулах албаны шинжээчийн албан тушаалд нэр дэвшигч Г.Нургүлийн ажилд томилуулахыг хүссэн гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай | 1.Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 273 дугаар захирамжийг хүчингүй болгох, 2.Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулган байнгын хорооны хуралдаан зохион байгуулах албаны шинжээчийн албан тушаалд Р.Нургүлийг 2009 оны 10 дугаар сарын 20-ны дотор томилохыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад үүрэг болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гарав. |
| 3 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны даргаар ажиллаж байсан Д.Жаргалсайханы гаргасан гомдлыг шалгасан Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай | ”Сахилгын шийтгэл ногдуулах тухай” Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын 2009 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 15 дугаар захирамжид үндэслэсэн Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д зааснаар түүнийг төрийн албанаас чөлөөлсөн нь хууль зөрчөөгүй байна гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэсэн МУ-ын ТАЗ-ийн тогтоол гарав. |
| 4 | Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт Сүхбаатар дүүрэг хариуцсан эрхийн | 1.Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт Сүхбаатар дүүрэг хариуцсан эрхийн бүртгэгчээр |

| | | |
|---|---|--|
| | <p>бүртгэгчээр ажиллаж байсан Ц.Билэгсүхийн гаргасан гомдлыг шалгасан Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай</p> | <p>ажиллаж байсан Ц.Билэгсүхийг “Ажлаас чөлөөлөх тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2009 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 39 дүгээр тушаалаар тухайн байгууллагын бүтэц, орон тоо батлагдсантай холбогдуулан уг тушаалын 2 дугаар хавсралтад дурдсан Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын гэрээний хэлтсийн албан хаагчдын хамт ажлаас нь чөлөөлсөн боловч өмнөх ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн, 2008 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр В /86/ үнэлгээ авсан байхад түүнийг ажилд нь эргүүлэн томилоогүй нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.3-т заасныг зөрчсөн байна гэсэн Маргаан хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх, 2.Ц.Билэгсүхийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын эрхийн улсын бүртгэлийн бүртгэгчээр томилохыг Улсын бүртгэлийн ерөнхий газар /Л.МӨНХБААТАР/-т даалгах тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 5 | <p>Засгийн газрын агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний тухай</p> | <p>1.Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг: Дарга: -Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, гишүүдэд: Захиргаа, улсын бүртгэл, мэдээлэл технологийн асуудал эрхэлсэн орлогч дарга, Бүртгэл хяналт, улсын бүртгэлийн төв архив, орон нутгийн асуудал хариуцсан орлогч дарга, Тамгын газрын дарга, Хуулийн хэлтсийн дарга, Иргэний бүртгэлийн газрын дарга, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга, Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга, Бүртгэлийн хяналтын газрын дарга, Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад: -Тамгын газрын (хүний нөөцийн асуудал хариуцсан) ахлах мэргэжилтэн гэсэн 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах, 2.Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргад Салбар зөвлөлийн орон тооны бус ажлын албаны даргын үүргийг хүлээлгэн ажиллуулахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад зөвлөх тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 6 | <p>Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах тухай</p> | <p>Өөрчлөлт оруулав.</p> |
| 7 | <p>Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дэд даргын, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Оюуны өмчийн газрын дэд дарга нарын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд санал дүгнэлт гаргах тухай</p> | <p>1)Цэсэнгийн Пүрэвдоржийг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүртгэлийн хяналт, улсын бүртгэлийн архив, орон нутгийн асуудал хариуцсан дэд даргын; 2)Самдангийн Энхбаатарыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Захиргаа, улсын бүртгэл, мэдээллийн технологийн асуудал</p> |

| | | |
|---|--|--|
| | | <p>хариуцсан дэд даргын;</p> <p>3)Сэмжидсүрэнгийн Гантөмөрийг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газрын дэд даргын албан тушаалд тус тус нэр дэвшүүлэх тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>4)Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дэд даргын албан тушаалд нэр дэвшигч Цэдэнсамбын Доржпаламын талаар тодруулахаар хойшлуулав.</p> |
| 8 | <p>Бусад асуудал: 2009 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад өрсөлдсөн Ц.Мөнх-Эрдэнэ, Г.Цолмон нарын болон Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай</p> | <p>1.2009 оны 5 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир, спортын газрын “Бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг хангуулах, бүх төрлийн спортын уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулах, төлөвлөлт, явц, чанар, сургалтын үр дүн” хариуцсан мэргэжилтний ажлын байранд өрсөлдөж, 55.0 оноогоор тэнцсэн Цэдэндолгорын Мөнх-Эрдэнийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай ТА3-ийн тогтоол гаргав.</p> |

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ